



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 05 сарын 04 өдөр

Дугаар 8/16

Ховд

Г А.Өлзийбаярыг ажилд томилох тухай Г

Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.15 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн Ховд аймаг дахь салбар зөвлөлийн 2020 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн “Нэр дэвшүүлэх тухай” 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Авлигатай тэмцэх газрын 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 05/10190 тоот албан бичгээр хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг нь хянагдаж ирсэн Алагаагийн Өлзийбаярыг 10 дугаар цэцэрлэгийн эрхлэгчийн албан тушаалд 2020 оны 05 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн томилсугай.

2. Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолын 5 дугаар хавсралт “Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн сүлжээ”-ний ТҮБД-5-3 дахь шатлал болох 912097 төгрөг /Есөн зуун арван хоёр мянга ерөн долоон/-өөр, Төрийн албан хаасан хугацааны нэмэгдлийг Засгийн газрын 2018 оны “Журам батлах тухай” 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын дагуу үндсэн цалингийн 10 хувиар тус тус тооцож цалинжуулахыг тус цэцэрлэгийн нягтлан бодогч /Л.Сонинбаяр/-д зөвшөөрсүгэй.

3. Авлигын эсрэг хууль болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, ашиг сонирхлын зөрчил үүссэн тохиолдол бүрт тайлбар, мэдүүлэг гаргаж ажиллахыг А.Өлзийбаярт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

02 01286
D/Zax-B/16-Da